



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/327

Хэрлэн сум

**Мөнгөн зээлийн үйл  
ажиллагааны зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Батноров сумын 7 дугаар баг Бэрх тосгоны 65 байрны 25 тоотод мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн Дүүрэн итгэлт бэрх ХХК (4207262)-ний өргөдөл холбогдох баримт бичиг нь шаардлагад нийцсэн тул мөнгөн зээлийн үйл ажиллагааны зөвшөөрлийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн олгосугай.

2.Тусгай зөвшөөрлийн бүртгэлийг санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлийн цахим санд холбогдох журмын дагуу бүртгэж, олон нийтэд ил тод мэдээллэхийг Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгч, Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн (Д.Наранцацрал)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгч, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ